



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/154

Улаанбаатар хот

Журам батлах тухай

"МУБИС-ийн Дүрэм" –ийн 4.4.1, МУБИС-ийн Захирлын зөвлөлийн 2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. "МУБИС-д хичээл дүйцүүлэн тооцох журам" -ыг хавсралтаар баталсугай.
2. "МУБИС-д хичээл дүйцүүлэн тооцох журам" батлагдсантай холбогдуулан "Хөрвөх хөтөлбөр болон үндсэн хөтөлбөрт шууд элсүүлэх сургалтыг зохион байгуулах үйл ажиллагааны удирдамж" (2016), "Мэргэжлийн магистрын сургалт зохион байгуулах тухай удирдамж (2018)" болон "Сургалтын журам"-ын 4.12.7, 4.12.8 дахь заалтуудыг тус тус хүчингүй болгосугай.
3. Мөн "Сургалтын журам"-ын 4.12.4 дэх заалтыг "Шилжин ирж буй суралцагчийн хичээл дүйцүүлэлтийг тусгай журмаар зохицуулна" хэмээн өөрчилсүгэй.
4. "МУБИС-д хичээл дүйцүүлэн тооцох журам"-ын 2.8 болон 3.7.2-т заасан телбөрийг 2020-2021 оны өвлийн улирлын элсэгчдээс эхлэн авахыг бүрэлдэхүүний сургуулийн захирлуудад зөвшөөрсүгэй.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт эрхэлсэн дэд захирал /Х.Тамир/-д даалгасугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Д.МАНДАХ



МУБИС-ийн захирлын
2020 оны 09 дүгээр сарын 22 -ны
өдрийн А/154 тушаалын хавсралт

9019100810
АТАЗЗ01 9087702

МУБИС-д хичээл дүйцүүлэн тооцох журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсын Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2015-2025 он), Боловсролын тухай хууль (2002 он), МУБИС-ийн Хөгжлийн бодлого (2014-2024 он), МУБИС-ийн Сургалтын журам болон холбогдох дүрэм, журмыг үндэслэл болгоно.
- 1.2. Энэхүү журмын зорилго нь оюутны өмнө судалсан хичээл, тэдгээрийн кредит, үнэлгээ мөн олон улсын хэлний шалгалтын оноог МУБИС-д дүйцүүлэн тооцоход оршино.
- 1.3. Тус журмаар МУБИС-ийн сургалтын үйл ажиллагаан дахь дараах харилцааг зохицуулна. Үүнд:
 - Бакалавр, магистр, докторын хөтөлбөрт шилжин суралцаад оюутны өмнө судалсан хичээлийг дүйцүүлэх
 - 1+2, 2+1, 2+2, 3+1 зэрэг гадаад, дотоодын их дээд сургуультай хамтарсан хөтөлбөрөөр суралцагчдын хичээл болон тэдгээрийн кредит, үнэлгээг дүйцүүлэх
 - Оюутан солилцооны хөтөлбөрөөр суралцагчдын бусад их дээд сургуульд судалсан хичээл болон тэдгээрийн кредит, үнэлгээг дүйцүүлэх
 - Зэрэг ахиулах болон хөрвөх хөтөлбөрт элсэгчдийн өмнө судалсан хичээл болон тэдгээрийн кредит, үнэлгээг дүйцүүлэх
 - Мэргэжлийн магистрт элсэгчдийн бүтээлийг мэргэжлийн хичээлтэй дүйцүүлэх
 - Бакалавр, магистр, докторын хөтөлбөрт суралцагчдын олон улсын хэлний шалгалтын оноог гадаад хэлний хичээлтэй дүйцүүлэх
 - Шууд шалгалтаар хичээл тооцуулахтай холбоотой харилцаа тус тус багтана.
- 1.4. Дүйцүүлэлт хийхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - Суралцагч нь ижил түвшний мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад суралцсан байх;
 - Суралцагч элсэлтийн болон суралцах хугацаанд хамаарах баримт бичгийн зөрчилгүй, зохих шалгуурыг хангасан байх;
 - Дүйцүүлэлт хийх үйл ажиллагаа нь хэн нэгэнд давуу байдал үүсгэхгүй, дүрэм журмын хүрээнд, шударга, ил тод, үнэн зөв байх;
 - Дүйцүүлэлт хийх явцад суралцагчидтай хүндэтгэлтэй, ёс зүйтэй хандаж, тэднийг мэдээллээр бүрэн хангах;
 - Дүйцүүлэх боломжит бүх хувилбарыг тооцож, суралцагчдад суралцах боломж, нөхцлийг санал болгон арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэх;
 - Дүйцүүлэлт хийх хугацаа, хуваарь, үйл ажиллагааны аргачлал, дараалал тодорхой, нээлттэй байх;

Хоёр. Хичээл дүйцүүлэхэд тавих үндсэн шаардлага

- 2.1. Дараах их дээд сургуулийн хичээлийг дүйцүүлэн тооцно. Үүнд:
 - Магадлан итгэмжлэлийн хүчинтэй хугацаатай дотоодын их, дээд сургууль;
 - Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн хүчинтэй хугацаатай эсвэл олон улсын нэр хүнд бүхий ижил түвшний мэргэжилтэн бэлтгэдэг гадаадын их дээд сургууль;
 - Хамтын ажиллагааны гэрээтэй гадаад, дотоодын их, дээд сургууль тус тус хамаарна.
- 2.2. Хичээл дүйцүүлэхдээ албан ёсны баталгаажсан дүнгийн тодорхойлолт болон дипломыг үндэслэх бөгөөд дүйцүүлэх хичээлийн дүн 61 болон түүнээс дээш үнэлгээтэй, агуулгын хувьд суралцахуйн үр дүнгийн 70-аас доошгүй хувийн давхцалтай байна.
- 2.3. МУБИС-д хичээл дүйцүүлэх хувь хэмжээний дээд хязгаарыг дараах байдлаар тогтооно.

Хүснэгт 1. МУБИС-д хичээл дүйцүүлэн тооцох хувь хэмжээний дээд хязгаар

1	Бакалаврын сургалт		Ерөнхий суурь	Багш боловсролын суурь/Мэргэжлийн суурь	Мэргэжлийн хичээл
1.1	Хөрвөх	Багш - багш /мэргэжлийн вөр чиглэлд хөрвөх/	100%	100%	30%
1.2		Багш бус-багш /математикчaaс математикийн багш гэх мэт/	100%	30%	70%
1.3		Өөр мэргэжил - багш /сэтгүүлчээс математикийн багш гэх мэт/	100%	20%	20%
1.4	Шилжин суралцах		100%	70%	50%
1.5	2+2 зэрэг хамтарсан хөтөлбөр		50%	50%	50%
1.6	Бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцагч шууд шалгалтаар хичээл тооцуулах (тус журмын 2.7 дахь заалт)		30%		
2	Төгсөлтийн дараах сургалт		Үндсэн суурийн хичээл	Мэргэжлийн суурь хичээл	Сонгон суралцах хичээл
2.1	Магистр (шилжин ирэх)	Гадаадаас (10 кр)	30%	30%	30%
2.2		Дотоодоос (6 кр)	20%	30%	30%
2.3	Мэргэжлийн магистр				70%
2.4	Доктор (шилжин ирэх)	Гадаадаас (20 кр)	30%	30%	30%
2.5		Дотоодоос (9 кр)	20%	30%	30%

- 2.4. Хөрвөх хөтөлбөрт элсэгч хичээл дүйцүүлэлт хийх үед хүсэлт гарган сургалтын төлөвлөгөөний хичээлүүдээс судлах шаардлагагүй гэж үзвэл шууд шалгалтаар тооцуулж болно.
- 2.5. Шууд шалгалтаар тооцох хичээлийн жагсаалтыг тухайн мэргэжлийн хөтөлбөрийн дэд хороо хэлэлцэн Хүснэгт 2-ын дагуу тогтоож бүрэлдэхүүн сургуулийн Хөтөлбөрийн албаар баталгаажуулан Сургалтын хөтөлбөр, багшийн хөгжлийн албанад ирүүлнэ.

Хүснэгт 2. хөтөлбөрийн шууд шалгалтаар тооцуулах хичээлийн жагсаалт

№	Суралцах хөтөлбөр	Ерөнхий суурь	Багш боловсролын суурь	Мэргэжлийн хичээл
1	Бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцагч	Хичээл – 1 Хичээл – 2		
2	Багш - багш /мэргэжлийн өөр чиглэлд хөрвөх/	Хичээл – 1 Хичээл – 2	Хичээл – 1 Хичээл – 2	Хичээл – 1 Хичээл – 2
3	Багш бус-багш /математикчаас математикийн багш гэх мэт/	Хичээл – 1 Хичээл – 2	Хичээл – 1 Хичээл – 2	Хичээл – 1 Хичээл – 2
4	Өөр мэргэжил - багш /сэтгүүлчээс математикийн багш гэх мэт/	Хичээл – 1 Хичээл – 2	Хичээл – 1 Хичээл – 2	Хичээл – 1 Хичээл – 2

- 2.6. Шууд шалгалт өгөх элсэгчийн нэр, хичээл бүхий захиалгыг бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн алба нэгтгэн Сургалтын хөтөлбөр, багшийн хөгжлийн албанад ирүүлнэ. Шалгалтыг улирал бүрийн 3 дахь долоо хоногт онлайнаар Сургалтын хөтөлбөр, багшийн хөгжлийн алба зохион байгуулна.
- 2.7. Бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцагч “Сургалтын журам”-ын 4.6.29-д заасны дагуу шууд шалгалтаар хичээл дүйцүүлж болно. Энэ тохиолдолд тухайн улирлын хичээл Сонголт-2 хийхийн өмнө харьяа хөтөлбөрийн албанад мэдэгдэж бүртгүүлсэн байна. Шалгалтыг тус журмын 2.6-д заасны дагуу зохион байгуулна.
- 2.8. Шууд шалгалтаар тооцуулах хүсэлт гаргасан бол шалгалтын зардал болох тухайн хичээлийн нийт кредитийн төлбөрийн 35% - ийг төлнэ.
- 2.9. Хэрэв шалгуулагч хангалтгүй дүн үзүүлсэн бол шалгалтын төлбөрийг буцаахгүй бөгөөд тухайн хичээлийг дахин судална.
- 2.10. МУБИС-ийн бэлтгэл бүлэгт судалсан хичээлийг дүйцүүлэн тооцож болно. Энэ тохиолдолд суралцагч МУБИС-д элсэн суралцах болзолыг хангасан байна.

- 2.11. МУБИС-ийн Монгол хэлний бэлтгэлд суралцсан гадаад оюутан үндсэн хөтөлбөрт элсэн суралцах тохиолдолд бэлтгэл хөтөлбөрт судалсан хичээлийг үндсэн хөтөлбөрийн хичээлтэй дүйцүүлэхгүй.
- 2.12. МУБИС-ийн төгсөгч дараагийн шатны сургалтад элсэн суралцах тохиолдолд хоёр түвшинд зэрэг судалдаг хичээлийг дүйцүүлж болно. Дүйцүүлэх хичээлийн хэмжээ 6 кредитээс ихгүй байна.

Гурав. Хичээл дүйцүүлэх үйл ажиллагаа

- 3.1. Ерөнхий суурийн болон Багш боловсролын хичээлийн дүйцүүлэлтийг бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн албаны мэргэжилтэн, мэргэжлийн хичээлийн дүйцүүлэлтийг тухайн мэргэжлийн тэнхимийн эрхлэгч хийж, хөтөлбөрийн албаны дарга хянан МУБИС-ийн хичээл дүйцүүлэлтийн комисст хүргүүлнэ.
- 3.2. Бүрэлдэхүүний сургуулиас ирсэн дүйцүүлэлтийг МУБИС-ийн захирлын тушаалаар батлагдсан Хичээл дүйцүүлэлтийн комисс хянаж, Сургалт эрхэлсэн дэд захирал баталгаажуулна.
- 3.3. Бэлтгэж буй мэргэжил болон сургуулийн онцлогоос шалтгаалан бүрэлдэхүүн сургууль дээр дүйцүүлэлтийн комисс ажиллуулж болно. Энэ тохиолдолд тус журмын 3.1-т заасан дүйцүүлэлтийн комиссын өмнө шалгасан байна.
- 3.4. Дүйцүүлэлтийг улирал бүрийн эхэнд кредит нэгтгэлийн тушаал гарахаас өмнө хийж, баталгаажуулсан байна.
- 3.5. Мэргэжлийн магистраас бусад хичээлийн дүйцүүлэлтийг энэхүү журмын ХАВСРАЛТ 1-ийн "Хичээл дүйцүүлэлтийн хуудас"-ыг ашиглан хийнэ.
- 3.6. Багш мэргэжлийн хөрвөх хөтөлбөрт элсэгч СӨБ, ЕБС-д 2-оос дээш жил багшилж байгаа бол Танилцах болон Судлах дадлага, Мэргэжлийн удиртгал хичээлийг албан ёсны тодорхойлолтыг үндэслэн дүйцүүлж болно. Энэ тохиолдолд дүнг тухайн элсэгчийн багшилсан жил, сургалтын чиглэлээр гаргасан амжилт, хичээл заасан суралцагчдын сурлагын амжилт, чанарт үндэслэн Хөтөлбөрийн алба дүйцүүлэн тавьна .
- 3.7. Мэргэжлийн магистрын хичээл дүйцүүлэлтийг хийхэд дараах зүйлийг мөрдлөг болгоно. Үүнд:
 - 3.7.1. ЕБС, СӨБ болон суралцаж буй мэргэжлийнхээ чиглэлээр 10 буюу түүнээс дээш жил ажилласан, өөрийн бүтээлтэй суралцагчийн зөвхөн мэргэжлийн хичээлийг дүйцүүлнэ.
 - 3.7.2. Бүтээлээр дүйцүүлсэн хичээлийн кредитийн төлбөрийн 60 хувийг хөнгөлнө. Суралцагч үлдсэн төлбөрийг дүйцүүлэлт хийж баталгаажсаны дараа кредит нэгтгэлийн тушаал гарахын өмнө төлсөн байна.
 - 3.7.3. Дүйцүүлэлтийг энэхүү журмын ХАВСРАЛТ 2-ын "Мэргэжлийн магистрын хичээл дүйцүүлэлтийн хуудас"-ыг ашиглан мэргэжлийн тэнхим хийнэ.
 - 3.7.4. Шалгуур үзүүлэлтийг хангасан бүтээлийн агуулга, тооцох кредитийг үндэслэн сургалтын төлөвлөгөөнд байгаа хичээлтэй дүйцүүлнэ.

- 3.7.5. Мэргэжлийн тэнхим дүйцүүлэлт хийхдээ бүтээлийн эх хувийг үндэслэх бөгөөд дүйцүүлэлтийн хуудсанд суралцагчийн бүтээлийн хуулбарыг хавсаргана.
- 3.8. Суралцагч дүйцүүлэлтийг зөвхөн нэг удаа хийлгэх эрхтэй.
- 3.9. МУБИС-ийн Чанарын баталгаажилт, хяналт үнэлгээний албанаас төгсөлт болохоос 1 улирлын өмнө бүрэлдэхүүн сургуулийн хичээл дүйцүүлэлтийг шалгах бөгөөд алдаатай хийсэн дүйцүүлэлтийг цуцалж болно.
- 3.10. Хэрэв дүйцүүлэлтийг алдаатай хийсэн нь нотлогдвол буруутай этгээд МУБИС-ийн “Дотоод журам”-ын дагуу хариуцлага хүлээнэ.
- 3.11. Дүйцүүлэлт буруу хийгдсэн тохиолдолд суралцагч хичээлийг дахин судална.

Дөрөв. Кредит шилжүүлэн тооцох

- 4.1. Дотоодын болон гадаадын кредит ижил тодорхойлогдсон их, дээд сургуулийн кредитийн хэмжээг шууд тооцох бөгөөд өөрөөр тодорхойлогддог кредитийг шилжүүлэхдээ тухайн сургуулийн албан ёсны тайлбарыг үндэслэнэ. Гадаадын их, дээд сургуулиудад түгээмэл хэрэглэгддэг кредитийг дараах байдаар шилжүүлэн тооцно. Үүнд:

Хүснэгт 3. Гадаадын их дээд сургуулиудад түгээмэл хэрэглэгддэг кредитийг шилжүүлэн тооцох аргачлал

МУБИС	ECTS	АНУ*	БНХАУ	Япон	БНСУ	ОХУ**
1 кредит	2	1	1	1	1	2

* Улирлын кредитээд сууринсан кредит системтэй сургууль бол кредитийг 3/2 коэффициентэд хувааж тооцно.

** Кредитээр хэмжигдээгүй, танхимиийн цагаар тодорхойлогддог сургалтын системтэй бол 72 танхимиын цагийг 1 кредит гэж үзнэ.

- 4.2. Оюутны судалсан хичээлийн кредит нь МУБИС-ийн харгалзах хичээлийн кредитээс зөрүүтэй бол дараах байдаар шийднэ. Үүнд:
- 4.2.1. Тухайн хичээлийн суралцахуйн үр дүн нь МУБИС-тай ижил эсвэл 70 хувийн давхцалтай, кредитийн зөрүү 1-ээс ихгүй тохиолдолд дутуу кредитийн төлбөрийг төлүүлэн шууд дүйцүүлж болно.
- 4.2.2. Хэрэв 1-ээс их кредитийн зөрүүтэй бол дутуу кредитийн төлбөрийг төлүүлэн шууд шалгалтаар тооцуулж болно. Энэ тохиолдолд тус журмын 2.6 болон 2.8 дахь заалтыг мөрдлөг болгоно.
- 4.2.3. Кредит илүү байгаа тохиолдолд МУБИС-ийн дүйцэгдэх хичээлийн кредитээр тооцно.
- 4.3. Оюутны судалсан хэд хэдэн хичээлийн кредит болон суралцахуйн үр дүн нь нийлээд МУБИС-ийн харгалзах хичээлийн кредит, суралцахуйн үр дүнд хүрч байвал тухайн хичээлүүдийг нэгтгэн, дундаж дүнгээр нь дүйцүүлж болно.
- 4.4. Оюутны судалсан нэг хичээл нь МУБИС-ийн хэд хэдэн хичээлийн суралцахуйн үр дүнг хангасан, тэдгээр хичээлүүдийн кредитийн нийлбэрээс

багагүй байгаа тохиолдолд тэдгээр хичээлүүдийг тус тусад нь дүйцүүлж болно.

Тав. Оюутны үнэлгээ буюу дүнг дүйцүүлэн тооцох

- 5.1. Дотоодын зарим их дээд сургуулиудын дүн, хуучин үнэлгээний системийг хөрвүүлэн тооцоходоо Хүснэгт 4-ийг ашиглана.

Хүснэгт 4. Дотоодын зарим их дээд сургуулийн дүнг хөрвүүлэн тооцох аргачлал

МУИС	ШУТИС	ХААИС	АШУУИС	МУБИС	Хуучин үнэлгээг хөрвүүлж тооцох аргачлал
95-100	96-100	96.0-100.0	90-100	98-100	Онцсайн
				94-97	Онц /5/
				91-93	
90-94	91-95	90.0-95.9	80-89	88-90	сайн /4/
	88-90	87.0-89.9		84-87	
85-89	84-87	83.0-86.9		81-83	
80-84	81-83	80.0-82.9		78-80	дунд /3/
75-79	78-80	77.0-79.9		74-77	
	74-77	73.0-76.9		71-73	
	71-73	70.0-72.9		68-70	
65-69	68-70	67.0-69.9	60-69	64-67	
60-64	64-67	63.0-66.9		61-63	
	60-63	60.0-62.9		30-60	муу /2/
0-59	0-60	0-59.9	0-60	0-29	

- 5.2. Хүснэгт 4 - ийн хуучин үнэлгээг хөрвүүлэн тооцох аргачлалыг диплом нөхөн олгох, хөрвөх болон зэрэг ахиулах хөтөлбөрт элсэгчдийн дүнг шилжүүлэн тооцоход хэрэглэнэ.
- 5.3. Хангалттай, тооцов, тэнцэв гэсэн үнэлгээнүүдийг хөрвүүлэхдээ МУБИС-ийн “Сургалтын журмын 4.6.16”-д заасан үсгэн үнэлгээг тавьж, голч тооцохгүй.
- 5.4. Бусад дотоодын их дээд сургуулийн үнэлгээний систем МУБИС-иас өөр бол тухайн сургуулийн тайлбарыг үндэслэн тогтооно.

- 5.5. Гадаадын их, дээд сургуульд хэрэглэгддэг үнэлгээний системийг Хүснэгт 5-ын дагуу тооцно. Тухайн хүснэгтэд ороогүй үнэлгээг тухайн сургуулийн тайлбарыг үндэслэн тогтоох бөгөөд Хүснэгт 4-ийн Хуучин үнэлгээг хөрвүүлж тооцох аргачлалыг хэрэглэж болно.

Хүснэгт 5. Гадаадын их дээд сургуульд хэрэглэгддэг зарим үнэлгээний системийг хөрвүүлэн тооцох аргачлал

МУБИС		ECTS		Орос			Хятад	Япон	Өмнөд солонгос
A+	98-100	A	Exc	100	5	excellent	100	S/A 100	A+
A	94-97	A		95	5		95	S/A +95	A
		A		95	5		90		A
A-	91-93	A		90	5			S/A +90	A-
B+	88-90	B	Vgood	87	5	Good		A 89	B+
B	84-87	B		84	4			A 89	B
B-	81-83	B		83	4		80	A 85	B
		B		80	4			A 85	B-
C+	78-80	C	Good	79	3	satisfactory	79	A 80	D+
C	74-77	C		75	3		75	B 79	D
C-	71-73	C		75	3		75	B 75	D
C-	71-73	C		70	3		70	B 75	D-
D+	68-70	D	Satis	65	3		69	B 70	
D	64-67	D					65	C 69	
D-	61-63	E	Pass				65	C 65	
F	30-60	F					60	C 60	
W	0-29	F	Fail	fail	fail		59>	F/D 40-59	F
								F/E <40	

- 5.6. Дүйцүүлсэн хичээлийн үсгэн үнэлгээг “Сургалтын журам”-ын 4.6.16-д заасны дагуу CR гэж тэмдэглэнэ. Голч дүн нь МУБИС-ийн харгалзах дүн байна.

Зургаа. Гадаад хэлний шалгалтын оноог дүйцүүлэн тооцох

- 6.1. Бакалавр, магистр, докторын суралцагч олон улсын хэлний шалгалт /iBT TOEFL, IELTS, TRKI, HSK, TOPIK, JLPT /-ыг 60 буюу түүнээс дээш хувьтай өгсөн шалгалтын онооны хугацаа хүчинтэй байгаа тохиолдолд сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурийн гадаад хэлний харгалзах заавал болон сонгон судлах хичээлийн аль нэгтэй дүйцүүлж болно.
- 6.2. Гадаад хэлний мэргэжлээр суралцаж буй бакалавр, магистр, докторын оюутнууд тухайн хэлнийхээ олон улсын шалгалтын дараах оноог авсан бол мэргэжлийн чадварын хичээлүүдээс 6 хүртэл кредит дүйцүүлэн тооцож болно.

Хүснэгт 6. Дүйцүүлэлт хийх олон улсын шалгалтын онооны босго.

CEFR	IELTS /9.0/	TOEFL /120/	TOEIC /1390/	ТРКИ	JLPT	TOPIK	HSK	TestDaf
C2 /Мэргэжлийн/	8.5-9.0	*	*	ТРКИ 4	N1	TOPIK II (Level 6)	HSK 6	*
C1 /Гүнзгий/	7.0-8.0	95-120	1305-1390	ТРКИ 3	N2	TOPIK II (Level 5)	HSK 5	TDN 5
B2 /Ахисан дунд/	5.5-6.5	72-94	1095-1304	ТРКИ 2	N3	TOPIK II (Level 4)	HSK 4	TDN 3-4
B1 /Дунд/	4.0-5.0	42-71	790-1094	ТРКИ 1	N4	TOPIK II (Level 3)	HSK 3	

6.3. Энэхүү журмын 6.1 болон 6.2-т заасан дүйцүүлэлтийг гадаад хэлний мэргэжлийн тэнхим хийж, бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн албаны дарга хянан баталгаажуулах бөгөөд нотлох баримтыг хавсаргасан байна. Мэргэжлийн тэнхим дүйцүүлэх хичээл болон дүнгийн тодорхойлолтыг энэхүү журмын ХАВСРАЛТ 3-т байгаа “Гадаад хэлний шалгалтын оноог дүйцүүлэн тооцох хуудас”-ыг ашиглан гаргаж суралцагчийн харьяа хөтөлбөрийн албанда хүлээлгэн өгнө.

ХАВСРАЛТ 1

ХИЧЭЭЛ ДҮЙЦҮҮЛЭЛТИЙН ХУУДАС

Огноо:

Хүснэгт гаргагчийн овог нэр:
Сурж байсан/төгссөн сургууль:

Суралцах хөтөлбөр:
Өмнөх боловсролын зөвхөн/дипломын №:

- Шилгиж ирсэн бакалаврын суралцагч
- Шилгиж ирсэн магистрын суралцагч
- Шилгиж ирсэн доцторын суралцагч
- Бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцагч
- Хөрвөх хөтөлбөрт суралцагч
- Хамтарсан хөтөлбөрт суралцагч

Хичээлний код	Хичээлгүүд	Дүйцүүлэх хичээл				Шалгалтаар тооцуулах	Судлах хичээлийн тооцуулах	Кредит	Нэр	Кредит
		Хичээлийн нэр	Кредит	Хувьч. оноо	Үсгэн үнэлгээ *					
I. БАГШ БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ СУУРЬ	A. ЕРӨНХИЙ СУУРЬ ХИЧЭЭЛ									
	Заавал суралцах хичээл									
	Сонгон суралцах хичээл									
B. БАГШ БОЛОВСРОЛЫН СУУРЬ ХИЧЭЭЛ										
	Заавал суралцах хичээл									
	Сонгон суралцах хичээл									
II. МЭРГЭЖЛИЙН СУУРЬ (БАГЦЫН)										
	Заавал суралцах хичээл									
	Сонгон суралцах хичээл									
III. МЭРГЭЖЛИЙН										
	Заавал суралцах хичээл									
	Сонгон суралцах хичээл									
НИЙТ КРЕДИТ										

*Тайлбар: 1-3 багцад Мубис-ийн сургалтын төвлөвлөвөнд заасан бүх хичээл, тэдгээрийн код, кредитийг бичнэ.

* Тайлбар: Сургалтын журмын 4.6.16-д заасны дагуу дүйцүүлэх хичээлийн үсгэн үнэлгээ бүгд CR гэж байна.

Дүйцүүлэлт хийсэн.....Хөтөлбөрийн албаны мэргэжилтэн

.....Тэнхимийн эрхэлгэч

Зөвшөөрсэн:Өргөдөл гаргагч

Шалгасан:Хөтөлбөрийн албаны дарга

Хянасан:Хичээл дүйцүүлэлтийн комиссын дарга

БаталгаажуулсанСургалт эрхэлсэн дэд захирал

ХАВСРАЛТ 2

МЭРГЭЖЛИЙН МАГИСТРЫН ХИЧЭЭЛ ДҮЙЦҮҮЛЭЛТИЙН ХУУДАС

Овог:

Элссэн сургууль/тэнхим:
Нэр:

Суралцагчийн код:

ЕБС/ СӨБ-д болон мэргэжлийн чиглэлээр ажилласан жил

№	Болзот	Тооцох кредит	Шалгур Узүүлэлт	Сургалтын төлөвлөгөөний ямар хичээлтэй дүйцүүлэх	
				Хичээлжийн нэр	Кредит
1	Үндэсний хэмжээний сургалтын хөтөлбөр, сурх бичиг, гарын авлага боловтуулахад оролцсон байдал	Үндэсний хөтөлбөр, сурх бичиг, гарын авлага боловтуулахад оролцсон байдал	Үндэсний хөтөлбөр, сурх бичиг, гарын авлага боловтуулахад оролцсон байдал	Шалгур Узүүлэлт Ундэсний хөтөлбөр, сурх бичиг, гарын авлага боловтуулахад оролцсон байдал	Шалгур Узүүлэлт Узүүлэлтийг хангасан хотолгоо (бүтээгдүүний нэр, хамрах хүрээ, хэвлэгдсэн онгоо, тушаалт г.м.)
2	Суралцаач бурийг хөгжүүлэх сургалтын арга зүй, технологийн чиглэлээр судалгааны болон оноплын өгүүлэл хэвлүүлсэн байх	Суралцаач бурийг хөгжүүлэх сургалтын арга зүй, технологийн чиглэлээр судалгааны болон оноплын өгүүлэл хэвлүүлсэн байх	Суралцаач бурийг хөгжүүлэх сургалтын арга зүй, технологийн чиглэлээр судалгааны болон оноплын өгүүлэл хэвлүүлсэн байх	Сургалтад ашиглаж, 2xx доошгүй гарын авлагы болгооруулсан (гарын авлагыг тус бүрд 1 кр)	Сургалтад ашиглаж, 2xx доошгүй гарын авлагы болгооруулсан (гарын авлагыг тус бүрд 1 кр)
3	Олон улс, улс, аймаг, нийслэлийн чанартай төрөлжсөн	Олон улс, улс, аймаг, нийслэлийн чанартай төрөлжсөн	Олон улсын олимпиад, уралдаан тэмцээний өөрөө болон барилгасан шаардлыг өгүүлэх	Олон улсын олимпиад, уралдаан тэмцээний өөрөө болон барилгасан шаардлыг өгүүлэх	Олон улсын олимпиад, уралдаан тэмцээний өөрөө болон барилгасан шаардлыг өгүүлэх
5					

3	олимпиадуудад болон багшийн үр чадварын уралдаанд оролцож I-V байрт шалгарч байсан	(1-р байр-5 кр, 2-р байр-4 кр, 3-р байр-3 кр, 4-р байр-2кр, 5-р байр-1кр)	
		Улсын чанартай олимпиад үрэлдээн тэмцээнд өөрөө болон бэлтгэсэн шаав нь I-3-р байрт шалгарсан бол (3 кр) (1-р байр-3 кр, 2-р байр-2 кр, 3-р байр-1 кр)	
		Улсын чанартай олимпиад үрэлдээн тэмцээнд өөрөө болон бэлтгэсэн шаав нь 4-6-р байрт шалгарсан бол (1 кр)	
		Аймагийн олимпиад, үр чадварын уралдаанд оролцож 1-3 байрт шалгарсан бол (3 кр) (1-р байр-2 кр, 2-р байр-1 кр, 3-р байр-0,5 кр)	
4	Суралцаач бүрийг хөгжүүлэх хөёроос доошгүй арга зүйг сургалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлж Боловсролын технологийн хөгжлийн үндэсний санд бүртгүүлсэн байх	Сургалтын үйл ажиллагааны хүрээнд судалгаа хийж зохиц үр дүнд хүрч арга зүй технологиго Боловсролын технологийн хөгжлийн санд бүртгүүлсэн бол (2 кр)	2
		Сургалтын арга зүй технологийг сургалтын үйл ажиллагаанд дахь хэрэгжүүлж сургуульшийн хэмжээнд түүзэн дээлзэрүүлж бусдын хүртээл болсон бол бүтмээл тус бүр (1 кр)	
5	Дээрх арга зүйг технологийг хөёроос доошгүй сургуульд түгээн дэлгэрүүлж үр дүнд хурсан тухай аймаг нийслэлийн боловсрол, соёл, урлагийн газрын тодорхойполт	Зохиц үр дүнд хүрсэн талаар аймаг, нийслэлийн БСУГ-ын тодорхойполттой бол сургууль тутамд (1 кр)	2
6	МУБИС-ийн нэмэлт хөтөлбөрт хамраадаж маргэжил дээшүүлсэн байх	-Төрөлжсөн сургалт явлуулах зөвшөөрөл опасдэсн хөтөлбөр, нэмэлт хөтөлбөрүүдэд хамгаадаж байсан бол хөтөлбөр тус бүрд (1 кр)	2
	Бүтээлийн болон суралцаач бүрийг	Сургууль, аймаг, нийслэлийн БСУГ-ын дүнгэлт	

7	хөгжүүлэх арга зүйн талаар өөрийн үнэлгээ хийж ажиллаж буй сургууль, аймийн боловсрол соёлт урлагийн газраар хөгжүүлэн дүгнэлт гаргуулсан байх	2				
	НИЙТ	20 *				

* Нийт кредитийн дээд хэмжээ энэхүү журмын 2.3 дахь хэсэгт заасны дагуу 14 кредитээс ихтүй байна.

Зөвшөөрсөн: Сургалцагч

Дүйцүүлэлт хийсэн: Тэнхимийн эрхлэгч

Шалгасан: ХА-ны дарга

Хянасан: Хичээл Дүйцүүлэлтийн комиссын дарга

Баталгаажуулсан: Сургалт эрхэлсэн дэд захирагч

ГАДААД ХЭЛНИЙ ШАЛГАЛТЫН ОНООГ ДҮЙЦҮҮЛЭН ТООЦОХ ХУУДАС

Огноо:

Хүснэгт гаргагчийн овог нэр:
Бүрэлдэхүүн сургууль:
Суралцаж буй хөтөлбөр:

Бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцагч
 Магистрын хөтөлбөрт суралцагч
 Докторын хөтөлбөрт суралцагч

МУБИС-ийн Сургалтын төлөвлөгөөний хичээл

Хичээллийн код	Хичээлүүд	Кредит	Хувьч. оноо	Кредит	Үсгэн үнэлгээ *	Голч дүн
ЕРӨНХИЙ СУУРЬ ХИЧЭЭЛ	Заавал суралцах хичээл					
	Сонгон суралцах хичээл					
МЭРГЭЖЛИЙН СУУРЬ (БАГЦЫН)	Заавал суралцах хичээл					
	Сонгон суралцах хичээл					
МЭРГЭЖЛИЙН	Заавал суралцах хичээл					
	Сонгон суралцах хичээл					
	НИЙТ КРЕДИТ					

* Тайлбар: Сургалтын журмын 4.6.16-д заасны дагуу дүйцүүлсэн хичээллийн үсгэн үнэлгээ бугд СГ гэж байна.

* Жич: Энхху журмын 6.2-т заасны дагуу дүйцүүлэх мэргэжийн хичээллийн дээд хэмжээ 6 кр байна.

Дүйцүүлэлт хийсэн: Тэнхимийн эрхлэгч

Зөвшөөрсөн: Өргөдөл гаргагч

Баталгаажуулсан Хөтөлбөрийн албаны дарга